

Өвөрхангай аймгийн Санхүүгийн хяналт дотоод аудитын албаны 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө болон албаны даргын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр баталсан 29/02 тоот удирдамжийн дагуу Өвөрхангай аймгийн Онги Ус суваг ОНӨААТҮГазрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

## 1.Аудитын зорилго:

Онги Ус суваг ОНӨААТҮГазрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаа иж бүрэн, үнэн зөв, шударгаар хөтлөгдсөн эсэх, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй дотоод хяналтууд хэрэгждэг эсэх, санхүүгийн үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, шилэн данс хөтлөлт чанартай хийгдэж байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх, илэрсэн асуудалд зөвлөгөө өгөх зорилготой.

## 2.Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт:

Энэ удаагийн дотоод аудитыг зөвхөн санхүүгийн үйл ажиллагаанд чиглүүлэхийг зорьсон, мөн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн цаг хугацаанд аудитыг багтааж, үр дүнг тайлагнах шаардлагатай тул дээр дурдсан байгууллагын засаглалын бүтэц, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг бүхэлд нь авч үзэхгүй боловч эдгээрийн зөвхөн санхүүгийн үйл ажиллагаатай холбогдох хэсгийг хамруулна.

№	Илэрсэн асуудлууд	Өгсөн зөвлөмж
1	ТУЗ нь санхүүгийн төлөвлөгөөг баталдаг ч төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй, хяналт тавьдаггүй, оруулсан дүнгээр нь баталдаг.	<ol style="list-style-type: none"> <li>1. ТУЗ ажиллах журмаа боловсруулан баталж, мөрдөж ажиллах.</li> <li>2. ТУЗ нь алдагдалтай төсөв баталдаггүй байх, аймгийн Засаг даргын үйл ажиллаганы хөтөлбөртэй уялдуулах.</li> <li>3. ТУЗ нь орлогын төлөвлөгөөг орлого бүрийг үндэслэлтэй тооцоо судалгаанд суурилсан тооцоолол бүхий нэр төрөл тус бүрээр нь сайтар хэлэлцдэг байх.</li> <li>4. ТУЗ нь зарлагын төлөвлөгөөг зарлага тус бүрээр нь тооцооллыг хийхдээ норм, норматив, стандартыг үндэслэсэн эсэх, сүүлийн 3-5 жилийн дундажийг тооцож үзсэн эсэх, холбогдох зардлуудад хамаарах үйл ажиллагааны төлөвлөгөө байгаа эсэхийг харгалзан үзэж зардлын зүйл тус бүрээр хэлэлцдэг байх.</li> <li>5. ТУЗ нь санхүүгийн төлөвлөгөөний биелэлтэд улирал тутам хяналтыг хэрэгжүүлж ажиллах.</li> <li>6. ТУЗ нь байгууллагын үр дүн, ашигт ажиллагаанд суурилсан урамшууллын механизмыг нэвтрүүлэх, түүнд үндэслэн шийдвэр гаргадаг байх.</li> </ol>
2	Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэггүй.	<ol style="list-style-type: none"> <li>1. Эрсдэлийн удирдлагын багтай болж энэ үйл ажиллагааг эзэнжүүлэх.</li> <li>2. Эрсдэлийн удирдлагын бодлого, журамтай болох</li> </ol>

		<ol style="list-style-type: none"> <li>3. Байгууллагын ажилтан, албан хаагчдад эрсдэлийн талаар ойлголт өгөх</li> <li>4. Жил бүр байгууллагын үйл ажиллагаа, дотоод гадаад хүчин зүйлс болон санхүүгийн зорилтуудад учрах эрсдэлийг шинэчлэн тодорхойлж, тохиолдох магадлал учруулах үр дагавраар нь үнэлэх, албажуулах</li> <li>5. Эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, үр дүнг тооцож ажиллах</li> <li>6. Нэг албан тушаалтныг эрсдэлийн удирдлагаар сургаж мэргэшүүлэх, чадавхижуулах</li> <li>7. Гүйцэтгэх удирдлага нь байгууллагын хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэхдээ эрсдлийн чиглэлээр ур чадвар бүхий ажилтанг сонгон шалгаруулж авах</li> <li>8. Байгууллагын эрсдлийн түвшинг үнэлэн шатлал ахиулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх</li> </ol>
3	<p>Дотоод хяналт шалгалт хийгддэггүй. Үйл ажиллагаанд тавих хяналт сул.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн байгуулж, ажиллах журмаа боловсруулан баталж, мөрдөж ажиллах</li> <li>2. Байгууллагын эрсдэлийг үнэлгээнд тулгуурлан дотоод хяналтын нэгжийн хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжүүлэн үр дүнг тооцож ажиллах</li> <li>3. Дотоод хяналтын журманд дотоод хяналтыг эрсдэлд суурилсан байдлаар зохион байгуулах, байгууллагын ямар үйл ажиллагааг хамруулах, хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар тусгаж, дотоод хяналтын нэгж үр ашигтай ажилласан тохиолдолд хуулийн хүрээнд шагнаж урамшуулах хөшүүргийг бий болгох</li> <li>4. Байгууллагын дотоод хяналтын зураглалтай болж хамт олноороо мөрдөж, тасралтгүй ажиллах системийг бүрдүүлэх.</li> <li>5. Дотоод хяналтын нэгжийн 1-ээс доошгүй гишүүнийг Дотоод хяналтын мэргэшүүлэх сургалтанд хамруулах</li> </ol>
4	<p>Дулааны шугам дамжуулалтын төлбөрийн орлогыг дутуу төвлөрүүлдэг. Орлогын төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавьдаггүй.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Өөрийн эзэмшлийн болон ашиглалтын дулаан дамжуулах шугамын хэмжээг Орон нутгийн өмчийн газар, Арвайхээр сумын ЗДТГ-ын бүртгэлтэй тулган баталгаажуулах.</li> <li>2. Дулаан дамжуулах Хангамж-Өргөө, Хангамж-Орд, Өв пост, Мөнх босго, Арвай палас, Цэргийн ангийн уурын зуух зэрэг 6 уурын зуухтай гэрээ байгуулж, ДШДТөлбөрийн орлогыг бүрэн оруулж, орлогыг нэмэгдүүлж ажиллах.</li> </ol>

		<ol style="list-style-type: none"> <li>3. Өв-Илч ХХК, Газрын улаач ХХК, Арвай-Илч ХХК зэрэг 3 компанитай байгуулсан гэрээнд дулааны шугам нэмэгдсэнтэй холбоотойгоор өөрчлөлт оруулж дахин шинэчлэн байгуулж, ДШДТөлбөрийн орлогыг бүрэн оруулах</li> <li>4. Орлогын төлөвлөгөөний биелэлтэд сар, улирал, жил тутамд хяналт тавьж ажиллах.</li> <li>5. Орлого нэмэгдүүлэх талаар санаачлагатай ажиллах.</li> </ol>
5	Ухаалаг худгууд алдагдалтай ажилладаг.	<ol style="list-style-type: none"> <li>1. Арвайхээр сумын Засаг дарга, ажлын албатай хамтран хэрэглээний халуун усны тарифыг тогтоож тоолуурын системд холбон үр ашгийн тооцоог хийсний үндсэн дээр иргэдийг халуун усаар хангах ажлыг зохион байгуулах.</li> <li>2. Цахим худгуудад цахилгаан зарцуулалт бага шаарддаг халаагуурыг ашиглах, бусад зардал бууруулах технологийг нэвтрүүлэх замаар худгуудын ашигт ажиллагааг сайжруулах.</li> <li>3. Ухаалаг худгуудийн өртгийн тооцооллыг хийж, дүгнэлт гарган, ашигт ажиллагааг сайжруулах араг хэмжээг авч хэрэгжүүлэх.</li> </ol>
6	Мөнгөн кассаас баримтгүй, үр ашиггүй зардал гаргадаг.	<ol style="list-style-type: none"> <li>1. Анхан шатны баримтыг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэх анхан шатны баримтгүй гүйлгээг хийхгүй байх</li> <li>2. Кассын үйл ажиллагаанд тавих нягтлан бодогчийн хяналтыг эрс сайжруулах, няравын хариуцлагыг дээшлүүлэх бэлэн мөнгөний үлдэгдлийг бага түвшинд байлгах</li> <li>3. Кассаар орж байгаа орлогуудыг байгууллагын дансанд ажлын 1 өдөрт багтаан төвлөрүүлж байх.</li> <li>4. Байгууллагын Дотоод журмыг шинэчлэн батлах, хэт хавтгайруулан олгож байгаа мөнгөн урамшуулал, тэтгэмж, зардлуудыг зогсоох.</li> <li>5. Мөнгөн кассаас худалдан авалт хийхдээ анхан шатны баримтыг (И-баримт) заавал хавсаргах, мэдэгдлийн хуудсаар бэлэн мөнгө гаргахгүй байх</li> <li>6. Сар бүр кассын тайлан гаргаж, хяналт тавьж хэвших</li> </ol>
7	Шатахууны тайлан дутуу гаргадаг.	<ol style="list-style-type: none"> <li>1. Нягтлан бодогч аж ахуйн материалын тайланг анхан шатны баримттай нь тулган шалгаж хүлээж авдаг байх</li> <li>2. Нягтлан бодогч няравыг мэргэжил арга зүйгээр хангаж, үйл ажиллагаанд нь өдөр тутам хяналтыг хэрэгжүүлж ажиллах</li> <li>3. Байгууллагын дотоод журмын 10.11 заалт зайлшгүй байх шаардлагатай эсэхэд ТУЗ-аас шийдвэр гаргуулах. Шаардлагатай гэж үзсэн тохолдолд ямар</li> </ol>

		<p>албан тушаалтан ямар тохиолдолд, ямар зориулалтаар шатахуун хэрэглэж болохыг нарийн тусгаж өгөх.</p> <ol style="list-style-type: none"> <li>4. Албан хаагчдад шатахуун олгоходоо байгууллагын албан хэрэгцээнд хаашаа, хэдэн километр явахыг тооцож нягтлан бодогч хянасны дараа үнэн бодит тооцоонд үндэслэн шатахуун олгож, ажлын тайланг бичүүлж, хавсаргадаг байх.</li> <li>5. Жолоочийн тооцооны хуудсыг тухай бүр бичүүлж, хянаж байх.</li> <li>6. Төсвийн хэмнэлтийн хуулийг мөрдөж ажиллах.</li> </ol>
8	<p>Онги ус суваг ОНӨААТҮГ-аас ТУЗ-ын гишүүдэд олгох цалингийн хэмжээг тогтоосон баримт бичиг байхгүй байхад ТУЗ-ын 7 гишүүнд цалин олгосон.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1 Гүйцэтгэх захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар ТУЗ-ийн гишүүдэд хэдий хэмжээний цалин олгохыг тогтоох, үр дүнг тооцох</li> <li>2 ТУЗ нь ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийн явцтай тухай бүрд нь танилцан ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэх, ТУЗ-ийн үйл ажиллагааг тогтмолжуулах, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, удирдлагын үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх.</li> <li>3 ТУЗ нь байгууллагын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр санаачлагатай ажиллах, санхүүгийн тайланд хагас бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, илэрсэн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлж байх.</li> </ol>
9	<p>Харилцагч аж ахуйн нэгж байгууллага, иргэнтэй тооцоо нийлсэн актыг үйлдээгүй.</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн холбогдолтой хууль, журам, заавартай сайтар танилцаж судлах</li> <li>2. Харилцагч иргэн, аж ахуй нэгжтэй тооцоо нийлсэн актыг үйлдэж байх</li> <li>3. Өр авлагаа баталгаажуулж ажиллах</li> <li>4. Удаан жилийн насжилттай авлагыг шүүхийн байгууллаар шийдвэрлүүлэх</li> </ol>
	<p>Нийт өгсөн зөвлөмж</p>	<p>46</p>